

Төслийн тайлант хугацаа	2010 он
Төслийн нэр, код	“Хүн ам, жөндөр, НҮЭМ-ийн асуудлыг ядууралтай уялдуулах нь” MNG4P202 төсөл
Хандивлагч улс, олон улсын байгууллагын нэр	НҮБ-ын Хүн амын сан
Төслийн хэрэгжих хугацаа (эхлэх, дуусах огноо)	2007-2011 он
Төслийн хэрэгжих салбар	Хүн ам, хөгжил, ядуурал, жөндөр, гэр бүл
Төслийн хамрах хүрээ /төсөлд хамрагдах байгууллага, хот, аймаг, орон нутгийн нэгж/	Үндэсний хэмжээнд
Төслийн хүрээнд хийгдэх ажлууд, тэдгээрийг гүйцэтгэх төлөвлөгөө /он тус бүрээр/, гол зорилтот арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдал	<p>Төслийг хэрэгжүүлснээр</p> <ul style="list-style-type: none"> • Үндэсний болон орон нутгийн түвшний төлөвлөлт, төсөв боловсруулах үйл явцад хүн ам, жөндөр, НҮЭМ-ийн асуудлаарх тоон мэдээлэл, судалгааны үр дүнг ашиглан дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх • Үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн дэмжлэгтэйгээр хүн ам, жөндөр, НҮЭМ-ийн бодлого, хөтөлбөрүүдийн хяналт, зохицуулалын оновчтой механизмыг бэхжүүлэх гэсэн үр дүнд хүрэх юм. <p>Төслийн бичиг баримт болон жил бүрийн ажлын төлөвлөгөөнд НХХ-ийн сайд, НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгч нар гарын үсэг зурж баталгаажуулж байна. Санхүүжилтыг төслийн багаар хэлэлцсэн баталсан ажлын төлөвлөгөөг үндэслэн НҮБ-аас улирлаар урьдчилан олгодог.</p> <p>Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн гүйцэтгэлийг урирал бүр НҮБХАС, төслийн захиарал, хэрэгжүүлэгчдийн оролцоотой хэлэлцэж ирлээ. Төсөв, төлөвлөгөөний хэрэгжилт тогтмол хангалттай байна гэсэн үнэлгээг хийсэн.</p>
Төслийн хүрээнд тайлант хугацаанд /2010 оны байдлаар/ хийгдсэн ажлууд	<ul style="list-style-type: none"> • Геронтологийн төвтэй хамтран хороо, эмнэлгийн нийгмийн ажилтнуудад зориулан “Ахмад настан-хөгжлийн хүч” сэдэвт 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. • ҮСХ-той хамтран “Хүн ам, хөгжил, жөндөр, НҮЭМ-ийн тоо мэдээллийг бодлого, төлөвлөлтөд ашиглах нь” сэдэвт сургалтыг 4 бүсэд зохион байгуулж, нийт 130 гаруй аймгийн ЗДТГ, түүний харьяа байгууллагын удирдлагыг хамрууллаа. • “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” сэдэвт судалгааг дуусган, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлжээ. Түүнчлэн судалгааны үр дүнг танилцуулах уулзалтыг зохион байгуулж, төр, ТББ, эрдэмж шинжилгээ, судалгааны байгууллагын 50 гаруй хүнийг оролцууллаа. • “Хүн ам зүйн цонхны үе ба хөгжлийн бодлогын зарим асуудлууд” Үндэсний зөвлөлдөх уулзалтыг УИХ-ын НББСШУБХ, ҮХШХ, НҮБ-ын Хүн амын сан, МУИС-ын ЭЗС-ийн Хүн амын сургалт, судалгааны төв хамтран зохион байгууллаа. Уулзалтаар хүн ам зүйн цонхны үеийг хэрхэн үр ашигтай ашиглах асуудлыг хэлэлцэн, зөвлөмж гаргасан. • Хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллагсдад зориулан “Хүн ам ба хөгжил” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 20 гаруй сэтгүүлчдийг хамруулсан. • Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд нийт 8 хөтөлбөрийн үе шатны төлөвлөгөө болон түүнийг хянах үзүүлэлтийг боловсруулсан. • “Өнөөгийн монголын гэр бүлийн хөгжлийн чиг хандлага, тулгамдсан асуудал” сэдвээр онол практикийн бага хурлыг зохион байгуулсан. • Аймаг, нийслэлийн дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, хүн амын асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан 2 удаагийн сургалт, семинар зохион байгуулсан. • Орцны гэр бүл болон хотын захын өрхийн аж байдлын

	<p>талаар телевизийн нэвтрүүлэг бэлтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Дараах сургалт сурталчилгааны материалыг хэвлүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - “Монгол Улсын хүн амын үндсэн үзүүлэлт-2009” Мэдээллийн хуудас - “Өнөөгийн монголын гэр бүлийн хөгжлийн чиг хандлага онол практикийн бага хурал-2008” Илтгэлийн эмхэтгэл - “Facts&figures: Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үндсэн үзүүлэлт” товхимол - Шинээр гэрлэгсдэд зориулсан гарын авлага - Хүн ам зүйн сэтгүүл - “Ахмад настны орлогын баталгаат байдлыг хангах нь: Монгол Улсын ахмад настны үзэл бодол” судалгааны тайлан - “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” судалгааны тайлан
Төслийн нийт төсөв /мян.доллараар/	216,5
Төслийн 2010 оны төсөв	110.5
2011 онд төслийн хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн томоохон ажлууд /огноо/	<ul style="list-style-type: none"> • Гэр бүл, хүн амын хөгжлийн асуудлаар хөтөлбөр боловсруулах • Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд “Шилжих хөдөлгөөн: Хотын захын болон орон дахь гэр бүл” төслийг боловсруулах, хэрэгжүүлж эхлэх • Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын НХХ-ийн дарга, ажилтнуудад зориулсан ээлжит сургалт семинар болон орон нутгийн түвшинд ажиллагчдын чадавхийг бэхжүүлэх сургалтууд • Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороог шинэчлэн зохион байгуулж ажиллуулах • Хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх • Хүн амын хөгжлийн тулгамдсан асуудлаар ухуулга, сурталчилгаа зохион байгуулах, гарын авлага, ном товхимол бэлтгэн хэвлүүлэх гэх мэт
Төслийн 2011 оны төсөв	156'7
Төслийн менежерийн нэр, хаяг, утас, электрон хаяг	<p>Төслийн захирал НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга У.Бямбасүрэн Утас: 263436 byambasuren@mswl.gov.mn Төслийн зохицуулагч: НХХЯ-ны СТГ-ын ахлах мэргэжилтэн С.Рэгзэн Утас 267635 regzen@mswl.gov.mn</p>
Төслийн хэрэгжилтэнд хяналт тавин ажилладаг төрийн байгууллагын холбогдох газар, хэлтэс, албан тушаалтны нэр, утас, электрон хаяг	<p>НХХЯ-ны СТГ-ын дарга Н.Аюуш, утас 265643 НХХ-ийн сайдын 2009 оны 71-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг</p>